

ЗААХ

У Д И Р Д А М Ж

ЗААХ

У Д И Р Д А М Ж

Юта, Солт Лэйк хот  
Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмээс хэвлэн гаргав

© 1994, 1999, 2001 by Intellectual Reserve, Inc.  
Бүх эрх хамгаалагдсан

Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв  
Англи эхийн зөвшөөрөл: 3/01  
Орчуулгын зөвшөөрөл: 8/08  
Teaching Guidebook -ийн орчуулга  
Mongolian

# Агуулга

Удиртгал	1
Өөрийгөө сүнслэгээр бэлд	3
Есүсийн адил заа	6
Төрөл бүрийн заах арга барилыг ашигла	12
Хичээлээ бэлтгэ	17
Зааж байгаа зүйлсээ ойлго	20
Заахын ашиг тус	22
Салбар дахь удирдаж буй багшийн өсөлт хөгжилт	24
Сайн мэдээг заах цуврал хичээлийн тэмдэглэл	26
Сүмийн материалуудыг цуглуулан, мэдээллүүдийг гэр бүлийн түүх дээр байрлуулах	28

## Удиртгал

Заах удирдамжийг үндсэн сургалтын хөтөлбөр болон сургалтын ерөнхий хөтөлбөрийг хэрэглэж буй нэгжийн гишүүд болон багш нар ашиглахад тохиромжтой (*Information for Priesthood and Auxiliary Leaders on Curriculum [36363]*). Энэхүү гарын авлага нь гишүүдийг гэртээ болон сүмийн үйл ажиллагаануудад заах чадвараа дээшлүүлэхэд нь тусална. Багш бүр хуулбарыг авах хэрэгтэй. Өрхийн тэргүүнүүдэд тус болох болно.



# Удиртгал

---

Энэ гарын авлага нь багш нар, удирдагчид болон эцэг эхчүүдэд зориулагдсан. Энэ нь багшийн хувьд өөрийгөө өсөж хөгжүүлэх хүч чармайлтын нэг хэсэг нь болон хэрэглэгдэх ба багш нарыг хөгжүүлэх сургалт болон сайн мэдээг заах цуврал хичээлийн суурь нь байж чадна (хуудас 21-22).

Их Эзэн заахдаа:

“Мөн хаант улсын сургаалыг та нар бие биедээ заах болно хэмээх зарлигийг Би та нарт өгч байна.

Та нар онол, зарчим, номлол, сайн мэдээний хуулинд, та нарын ойлголтгод шаардлагатай Бурханы хаант улсад хамаардаг бүх зүйл илүү төгс зааварлагдаж болохын тулд хичээнгүйлэн заагтун та нар мөн миний ач ивээл та нартай байх болно” гэжээ (С ба Г 88:77-78).



Эдгээрийг хийх хамгийн чухал газар нь гэр орон байх ёстой. Гэр орон нь сүм дээр суралцсан болон заагдсан зүйлсээр хүчирхэгжин

бэхждэг. Бид багшийн хувьд өдөр тутмынхаа амьдралд, хөршүүд болон, хамтран ажилладаг хүмүүсийнхээ төлөө үүрэг хариуцлага хүлээдэг. Бид ах эгч, эхнэр нөхөр, хүү охин, эцэг эхийн хувьд мөн айлчлагч багш, гэрийн багш, ангийн багш, сүмийн удирдагчид, найзууд, хөршүүд болон хамтран ажиллагсдын хувьд заадаг. Заримдаа бид үг яриа болон гэрчлэлээрээ бусдад заадаг ч ихэвчлэн өөрсдийнхөө үлгэр жишээгээр тэдэнд илүү ихийг харуулдаг.

Галилийн тэнгисийн хөвөөнд дахин амилсан Их Эзэн Петрт хандан: “Миний хонийг тэжээ” гэж сургасан байдаг (Иохан 21:16-17). Заах дуудлага нь хүмүүсийг Аврагч уруу чиглүүлэхийн тулд бусдын сэтгэлийг сайн мэдээний үнэнүүдээр тэжээхийг шаарддаг (Моронай 6:4). Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүдийн аврал дахь сайн мэдээний сургаалын үүргийн талаар бодоод үз дээ. Та үүнээс илүү ариун бас гайхамшигтай үүргийг төсөөлж чадах уу?

Хэрэв та эцэг эх юм уу шинээр дуудагдсан багш бол энэ үүрэг хариуцлагын талаар илүү их санаа зовж болох юм. Гэвч Их Эзэн танд туслахад үргэлж бэлэн гэдгийг санаарай. Хэрэв бид өөрсдийгөө даруусгаж мөн итгэлтэй байх

аваас Тэр бидний “сул дорой зүйлсийг маань хүчирхэг болгож өгнө” гэж амласан юм (Ифер 12:27).

Багш нарын хувьд өөрсдийн хүчин чармайлтаа өсгөхийн тулд бид олж авсан туршлагуудаа болон өөрсдийнхөө амьдралд хөгжүүлж

чадсан авьяас чадваруудаа ашиглаж болно. Бид Их Эзэнд найдаж, зааж байгаа хүмүүсээ хүчирхэгжүүлэхийг хичээн анхааралтайгаар хичээлээ бэлтгэснээр авьяас чадвараа дээшлүүлж чадна.

# Өөрийгөө сүнслэгээр бэлд



Та өөрийгөө сүнслэгээр бэлдсэ-  
нээр Ариун Сүнс заахад тань  
таныг удирдан чиглүүлж, туслах  
болно. Ариун Сүнс бол сайн мэдээ-  
ний үнэнүүд болон зарчмуудыг  
заахад зайлшгүй чухал юм. Их  
Эзэн хэлэхдээ “Мөн уг Сүнс итгэ-  
лийн залбирлаар та нарт өгөгдөх  
болно; мөн хэрэв та нар Сүнсийг  
эс хүлээн авбаас та нар заах нь  
үгүй” (С ба Г 42:14). Доорх зөвлөм-  
жүүд таныг Ариун Сүнсний удир-  
дамжтайгаар заахад туслах болно.

## Онцгойлон адис хүртэх нь

Заахаар дуудагдахдаа санваартны  
удирдагчаараа дамжуулан та онц-  
гойлон адислагдсан байх ёстой.  
Энэ адислал нь таныг дуудлагаа  
биелүүлэхэд туслах бөгөөд та заах  
дуудлагадаа үйлчлэхэд өөрийн

чадах бүхнээ хийснээр Их Эзэн  
таны бусдын сайн сайханд нөлөө-  
лөх чадварыг тань өсөн нэмэгдүү-  
лэх бөгөөд улмаар шаардлагатай  
үед таны чадвар болон авьяасаас  
илүүгээр таныг адислах болно.

## Ариун Сүнсний удирдамжийг эрэлхийл

Зааж байхдаа Ариун Сүнсийг эрэл-  
хийл. Тэрээр таныг зааж байгаа  
хүмүүсийнхээ хэрэгцээг нь ойлго-  
ход болон тэдний хэрэгцээнд  
тохируулан хичээл бэлтгэхэд тус-  
лах болно. Тэр таны зүрх сэтгэлийг  
зөөлрүүлж, нэмэлт удирдамж  
болон урам зоригийг хүлээн ава-  
хад тань таны оюун ухааныг бэл-  
дэх болно.



## Ойр ойрхон залбир

Ойр ойрхон залбиран таныг сурал-  
цаж мөн өөрийгөө бэлдэхэд Их  
Эзэн адислахыг түүнээс гуй. Зарим



үед та мацаг барин залбирч болно. Суралцагч бүрийг ойлгож, хайрлахын төлөө залбир. Танд ирэх Ариун Сүнсний өдөөлтийг таньж мэдэн түүнийг дагахын тулд суралц.

## Судруудаас суралц

Залбиралтайгаар судруудаас суралц. Ингэснээр та Аврагчийнхаа талаар суралцаж бас үнэний талаарх мэдлэгт өсч хөгжих болно. Ариун Сүнс таныг судруудыг ойлгоход мөн ангийн болон гэр бүлийн гишүүдийн хэрэгцээнд эдгээр нь хэрхэн ашиглагдаж болохыг мэдэхэд тань тусалдаг. Судраас суралцахдаа залбирал болон мацаг барилттай байснаар та илүү хүчирхэгжиж, заахдаа Ариун Сүнсээр удирдуулах болно.



## Сайн мэдээгээр амьдар

Та бүхий л чадлаараа сайн мэдээний сургаалын дагуу амьдар. Өнгөрсөн гэм нүглүүдээ наманчил. Эдгээрийг хийснээр та ойлголт болон хүчийг хүлээн авна. Сайн мэдээний дагуу амьдарснаар ирэх таны мэдэрдэг амар амгалан болон аз жаргал тань бусдад таны үзүүлэх нотолгоо, чин сэтгэлийн гэрчлэл болон үүрэг хариуцлагын тань хүчийг мэдрэх болно. Тэд таны амьдралын үлгэр жишээнээс суралцах болно.

Нэгэн багш заах хичээлээ бэлдэхэд Ариун Сүнсний удирдамжийг мэдэрч чадахгүй байжээ. Тэр тусламж хүсэн залбирах үедээ түүнд найрсаг бус хандсан хөршдөө уурласан бухимдал нь түүний зүрх сэтгэлд байсныг ухаарчээ. Түүнийг уучлахын тулд тэрээр Их Эзэнээс даруухнаар гуйн залбирав. Дараа өдөр тэр хөршийндөө айлчилж уучлал гуйжээ. Тэр хөрштэйгөө илүү дотно болж, Ариун Сүнсний удирдамжийг дахин мэдрэх боломжтой болсон юм.

## Даруу бай

Даруу байдал нь өөртөө хэт их анхаарал хандуулан өөрийн авьяас болон мэдлэгтээ найдах, уруу таталтуудаас зайлсхийхэд тань та нарт тусална. Номлогчийн Үгс 3:5-6-д: “Бүх зүрхээрээ Эзэнд итгэ. Өөрийн ойлголтод бүү түшиглэ. Өөрийн бүх замаараа Түүнийг

таньж мэд. Тэр чиний замыг шулуун болгоно” гэсэн зөвлөмжийг дагаснаар та даруу байдлаа харуулж чадна. Их Эзэн бидэнд: “Чи даруу бай; тэгвэл чиний

Бурхан Их Эзэн чамайг гараас чинь хөтөлж мөн залбирлуудад чинь хариу өгөх болно” гэж айлджээ (С ба Г 112:10).

## Есүсийн адил заа

---



### **Зааж буй хүмүүсээ хайрла**

Аврагч газар дэлхийд амьдарч байх хугацаандаа хүн бүрд агуу хайр болон ойлголтыг харуулсан. Тэр ядууст, баянд, хөөгдөгсдөд болон нүгэлтнүүдэд зааж байсан. Тэр бидэнд хүн бүрийг хайрлаж, бие биедээ туслахыг заасан. Тэр хэлэхдээ: “Би та нарт бие биеэ хайрлагтун. Би та нарыг яаж хайрласны адил та нар мөн бие биеэ хайрлагтун гэсэн шинэ тушаал өгч байна” (Иохан 13:34). Бид зааж буй хүмүүстээ хайраа үзүүлснээр тэд өөрсдийн мөнхийн үнэ цэнийг илүү ухамсарлаж, суралцах урам зориг нь нэмэгдэж, Ариун Сүнсэнд илүү сэргэг болох юм.

Сайн мэдээний багш байх гэдэг бол долоо хоног бүр хичээл заахаас илүү юм. Энэ нь бас ангийн гишүүдэд анхаарал халамж тавих гэсэн үг юм. Хүн бүртэй танилцахын тулд хүч чармайлт гарга. Энэ нь тэдэнд илүү үр дүнтэйгээр заахад тань туслах болно. Тахир дутуу болон хичээлд хамрагдахгүй байгаа ангийн гишүүдэд ямар нэгэн хүндрэлтэй асуудал байгаа үед тэдэнд чиний тусламж хэрэгтэй болно. Аврагчийн алдагдсан хурганы тухай сургаалт зүйрлэлийг санаарай (Лук 15:3-6).

Хичээлдээ алдаг оног ирдэг байсан нэгэн хүүхдийн ангийн багш нь түүнийг ирэх ням гарагт сүмд ирүүлэхийн тулд гэр бүлтэй нь долоо хоногийн турш холбоо тогтоожээ.

Эцэг эхтэй нь ярилцаж, хүүхдийнх нь төлөөх хайраа харуулахын тулд их хичээл зүтгэл гаргаж, аав ээжийг нь ажилтай үед түүнийг ангийн ямар нэгэн үйл ажиллагаанаас хоцруулахгүйн тулд сургуулиас нь хүртэл тосч авдаг байжээ.



Багш, гишүүдийг сайн мэдээнд хөрвөгдсөн хэвээр нь үлдэхэд туслахын тулд нөхөрсөг байх хэрэгтэй. Энэ нь ялангуяа шинэ гишүүдэд их чухал юм. Тэднийг ая тухтай байдлыг мэдрэхэд нь үргэлж тусал. Тэднийг хичээлд оролцуулах боломжуудыг эрж хай. Сайн мэдээний үнэнүүдийг хайр болон Ариун Сүнсээр заахын тулд өөрийгөө бэлтгэ.

## **Сайн мэдээний үнэнүүдийг заа**

Аврагч сайн мэдээний үнэнүүдийг заасан. Тэр эхний зарчмууд мөн ёслолууд болох итгэл, наманчлал, усан баталгаа болон Ариун Сүнсний бэлгийг хүлээж авах тухай онцолсон. Тэр бие биеэ хайрлаж мөн үйлчлэхийг бидэнд заасан. Түүнд

ирэхийн тулд Тэр бидэнд санваар, ёслолууд, гэрээнүүдийн талаар болон бид нарын байх ёстой, хийх ёстой мөн мэдэх ёстой бүгдийг заасан. Бид ч бас хожмын үеийн бошиглогчдын үгсийг болон судрууд дээр илчлэгдсэн сайн мэдээг заах ёстой. Бүдүүлэг үг хэллэг, хувийн үзэл бодол, дамын наймааны болон маргааны хэлбэртэй сэдвүүдийг заах нь зохистой бус юм.

Аврагч сайн мэдээний үнэнүүдийг маш энгийнээр заасан. Тэр өдөр тутмын амьдралаас ирдэг жишээнүүд, түүхүүд мөн ойлгомжтой цэвэр үг хэллэгүүдийг хэрэглэдэг байсан. Тэр хүмүүсийн ойлгож болохуйц энгийн туршлагауудыг хичээлдээ ашигладаг байсан. Тэр алдагдсан хургыг олох, зоосыг хайх болон үрэлгэн хөвгүүн эргэн ирэхэд баярлан тэмдэглэж байгаа тухай заасан (Лук 15).

Аврагч зааж байхдаа ойр ойрхон судруудыг хэрэглэдэг байжээ. Зааж байгаа хүмүүсээ хичээлийн турш судар хэрэглэхэд чиглүүл. Сударт гарч буй хүмүүс бүгд бодит байсан бөгөөд Их Эзэнд үйлчлэхийн тулд хүч чармайлтыг гаргаж байхдаа олон саад бэрхшээл болон баяр хөөртэй учирч байсныг ойлгоход нь тусал. Сударт байгаа хариултуудыг зааж буй хүмүүсээрээ олуулах асуултуудыг асуу. Хүн тус бүрийг гэртээ суралцахад нь урамшуулж, суралцсан

зүйлсээ хэрхэн үр дүнтэй болгох талаар заа. Сударт байгаа суралцах удирдамжуудыг хэрхэн ашиглахыг заа. Хожмын үеийн бошиглогчдын үгс болон судруудыг судлуулахын тулд гишүүдэд даалгавруудыг өг.

## Сүнсээр заа

Багш нар зааж байхдаа Их Эзэний сүнсийг өөрсөдтэйгөө хамт байлгаж болохын тулд эрэлхийлэх хэрэгтэй. Магадгүй хэн нэгэн нь гүн гүнзгий үнэнийг зааж, ангийн гишүүд хичээлд дуртай байж болох боловч, хэрвээ тухайн орчинд Ариун Сүнс л байхгүй бол эдгээр зүйлс нь зүрх сэтгэлд хүчтэй сэтгэгдлийг төрүүлэхгүй. Ариун Сүнсстэй хамт байгаа үед сайн мэдээний дагуу амьдрах үүрэг хариуцлагат болон Тэнгэрлэг Эцэг мөн Есүс Христийг мөн бие биеэ хайрлах хайранд хүчирхэгждэг. Та хичээлдээ Ариун Сүнсийг урихын тулд дараах зүйлсийг хийж болно.

- Залбирлаар эхэл.
- Хожмын үеийн бошиглогчдын үгс болон судруудаас заа.
- Гэрчлэлээ хуваалц.
- Туршлагаа хуваалцаж бас бусдыг хуваалцахыг урь.
- Дуу хөгжим ашигла (хуудас 10).
- Их Эзэн болон бусдад хайраа харуул.

Хэрэв та өөрийгөө зохистойгоор бэлдэх юм бол Ариун Сүнс таныг гэгээрүүлж, зааж байхад тань удирдах болно. Мөн зааж буй хүмүүсийнхээ талаар эсвэл тэдэнд зааж байхдаа юуг онцлох ёстой талаар удирдамж хүлээж авна. Та хүмүүст хэрхэн илүү сайн үр дүнтэйгээр зааж болох талаар санаанууд болон мэдрэмжүүдийг хүлээн авах болно. Та Ариун Сүнсний шивнээнд даруухнаар, дуулгавартай байснаар таны хичээнгүй зүтгэл өсөн нэмэгдэх болно. Түүгээр ч барахгүй та зааж байгаа хүмүүстээ Ариун Сүнсний нөлөөг мэдрэхэд нь туслах боломжтой.

## Хичээнгүй суралцахыг бий болго



Их Эзэн хэлэхдээ “Мэргэн ухааны үгсийг шилдэг номуудаас эрэлхийлэгтүн та нар; бүр судлахаар мөн тэрчлэн итгэлээр, суралцахыг эрэлхийлэгтүн” (С ба Г 88:118). Гишүүд бүр өөрсдийн хичээл зүтгэлээр

дамжуулан үнэний мэдлэгийг олж авах үүрэг хариуцлагатай билээ. Багшийн үүрэг хариуцлага нь бусдыг сайн мэдээний дагуу амьдрахад нь, судрыг суралцаж мөн ойлгох хүсэлтэй байхад нь тусалж, урамшуулах явдал юм. Энэ үүргийг биелүүлэхийн тулд дараах 3 зүйлд анхаарч болно:

1. Зааж буй хүмүүсийнхээ сонирхлыг төрүүлэх түлхүүр нь сайн мэдээг суралцаж байгаа таны урам зориг юм. Хичээлээ ойлгомжтой, санахад хялбар, сонирхолтой заах арга барилын нэг нь таны урам зориг юм (хуудас 9–12). Хичээлийн эхлэлд ялангуяа бусдын сонирхлыг төрүүлэх нь маш чухал. Хичээлээ төлөвлөхдөө сүнснийг урих арга замуудыг эрэлхийлж, хичээл дээр заагдах зарчмууд эсвэл сургаал дээр төвлөрч, хүн бүрийн сонирхлыг тат.
2. Хичээлийн оролцоог урамшуулан дэмж. Хичээлдээ бүх хүмүүсийг оролцуулах арга замуудыг төлөвлө. Та магадгүй хэн нэгнийг түүх хуваалцуулахаар, судар юм уу эшлэл уншуулахаар урьж болно. Мөн та хичээлийн сэдвийн талаар чөлөөтэй ярилцах болон асуултуудад хариулуулахаар мөн нэг буюу түүнээс дээш хүмүүсийг дуу дуулахаар эсвэл хөгжим тоглуулахаар урьж болох юм. Мөн та залбиралтайгаар хэн

нэгнийг хичээлийн сэдэвтэй холбоотой гэрчлэл болон хувийн туршлагаас нь хуваалцуулахаар сонгож болно. Заримдаа ийм оролцоог хүсэх нь маш чухал. Ингэснээр таны урьсан хүмүүс хичээлд оролцоход илүү таатай мэдрэмжийг мэдрэх дасгал болж өгөх юм.

Нэгэн багшийн хичээлийн гол санаа нь Мормоны Номоос унших нь ямар чухал болох талаар байсан юм. Тэр өөрсдийнх нь амьдралыг өөрчилсөн судрын хэсгийг бодохыг ангийн залуучуудаас хүсэв. Тэднийг судрын хэсгийг ангийн гишүүдтэй хуваалцаж мөн амьдралд нь хэрхэн нөлөөлснийг яриулахаар урив. Хүн бүр Мормоны Номын хүч болон гайхалтай мэдрэмжүүдийнхээ талаар хуваалцахад ангийн гишүүд судрыг өдөр бүр уншиж, тунгаан бодох хүсэл эрмэлзэлтэй болж байв.

Зарим хүмүүс хичээлд оролцоход дурамжхан байдаг. Тэднийг хичээлд оролцох таатай мэдрэмжийг мэдрэх хүртэл нь чангаар уншиж мөн залбирахыг бүү шаард. Хэрвээ таньд хүмүүсийн хичээлд оролцох бэлэн байдлынх нь талаар ямар нэгэн эргэлзээ байгаа бол дурамжхан нэгнийг биш саналаараа туслах хэн нэгнийг сонго. Хичээлд оролцож байгаа хүмүүсийг бусад

нь хэрхэн хүндэлж, найрсаг харьцаж буйг хүмүүс хараад хичээлд оролцох таатай мэдрэмжийг олж авахад баяртайгаар суралцах болно.

3. Сурсан зүйлсээ хэрэгжүүлэхэд нь тэдэнд тусал. Амьдралынхаа нөхцөл байдалд тохируулан заагдсан зүйлсийг хэрэгжүүлэхэд нь тэдэнд туслахын тулд ангийн гишүүдийг заасан үнэнүүдийн талаар туршлага хуримтлуулах даалгавар болон сорилтуудыг багтааж болно. Сайн мэдээнээс суралцах нь сайн мэдээгээр амьдраагүй үед ямар ч үнэ цэнэгүй гэдгийг санаарай.

## Суралцах орчныг бүрдүүл



Сайн мэдээг суралцах хамгийн шилдэг арга бол хүн тус бүр бүлгийнхээ бусад гишүүдийн суралцаж байгаад анхаарал хандуулах явдал юм. Суралцагсад болон багш нар бие биеэ хайрлан, сайн мэдээг ойлгож түүгээр амьдрахад нь бие

биедээ тусалсан үед сурах хүсэл эрмэлзэл илүү нэмэгддэг. Та болон таны зааж байгаа хүмүүс суралцах эерэг орчинг хамтдаа бий болгосноор гарч болох асуудлууд нь шийдвэрлэгдэх болно. Ийм орчинг бүрдүүлж, зааж байгаа хүмүүстээ хувь нэмрээ оруулахад нь туслахын тулд та өөрийн хийж чадах бүхнээ хийх хэрэгтэй.

Суралцах орчныг бий болгохын тулд дараах зүйлсийг хийж болно:

- Хичээл заахад шаардлагатай материалыг бүрдүүлэн цагаасаа өмнө ир.
- Анги цэвэр цэмцгэр, эмх цэгцтэй, болон гишүүдэд саад болох аливаа зүйлс байгаа эсэхийг шалга.
- Цагтаа эхэлж цагтаа дуусга.
- Хэрвээ боломжтой бол ангийн гишүүд бүрийг тус бүрд нь угтан авч мөн үд.
- Хүндэтгэлтэй болон еэлдэг байдлыг урамшуулан дэмжих сүнсийг урих зүйлсийг хий.
- Ангийн гишүүдийг хайрлаж, тэднийг хичээлд оролцох таатай мэдрэмжийг мэдрэхэд нь тусал.
- Гишүүдийг хичээлийн сэдэвт анхаарлаа төвлөрүүлэхэд туслах асуултуудыг асуу.
- Ангийн гишүүдийг бие биеэ хүндэлж мөн ойлгож, сонсохыг урамшуулан дэмж.

- Гэрчлэлийг үгүйсгэж сулруулах, сүнснийг үргээж болох ярилцлагын эсрэг зогсон хамгаал.

Суралцах орчинг бий болгохын тулд өөрийн чадах бүхнээ хийсний дараа ч та өөр бусад бэрхшээлүүдтэй тулгарч болох юм. Дараах зөвлөмжүүд нь нийтлэг тохиолддог бэрхшээл болон асуудлуудыг шийдвэрлэхэд танд туслах болно:

- Хэрэв асуудал гарвал хүн бүрийн анхаарлыг төвлөрөх хүртэл яриаг зогсоо. Тэгээд хичээлээ үргэлжлүүл.
- Хэрэв хүмүүс хичээлийн явцад хоорондоо ярьж, сатаарч байвал хичээлийн дараа тэдэнтэй ганцаарчлан уулзаж, хичээлийг илүү үр дүнтэй болгохын тулд тэд юу хийж болох тухай ярилц.
- Хэрэв хэн нэгэн нь ангийн яриаг давамгайлж эхэлвэл асуултыг ангийн өөр нэгэн гишүүнээс асуух эсвэл түүнд хичээлд оролцож хараахан амжаагүй байгаа хүмүүсийг сонсохыг найрсагаар зөвлө.
- Хэрэв ангийн гишүүд ярилцлагыг хичээлийн сэдвээс хөндийрүүлэх санал хэлэх юм бол түүнийг зөвшөөр, харин ярилцлагыг хичээлийн сэдэв уруу эргүүлэн чиглүүл.

Ангид байгаа хүн бүрийг хайраар хүрээлэгдсэн, хүлээн зөвшөөрөгдсөнөө мэдэрч мөн амжилттай хичээлд оролцох арга замуудыг хайж олсноор дэг журамгүй зан авир багасах болно.



## Төрөл бүрийн заах арга барилыг ашигла



Ангийн гишүүдийг сайн мэдээний үнэнүүдийг ойлгоход нь тусалж, хичээлээ илүү сонирхолтой болгохын тулд танд дараах зарим зөвлөгөөнүүдийг өгч байна:

### **Түүх болон жишээнүүдийг ашигла.**

Түүх болон жишээнүүд нь хүмүүсийн сонирхлыг төрүүлж, сайн мэдээний зарчмуудыг өдөр тутмынхаа амьдралдаа хэрхэн ашиглаж болохыг харуулдаг.

Та багшийнхаа гарын авлагаас болон судруудаас гайхалтай түүхүүд олох болно. Хичээлээ эхлэхээс өмнө хуваалцахаар төлөвлөж буй түүхээ судал. Тэдгээрийг

өөрийн болтол давт. Түүхийг өөрийн үгээр яривал таныг илүү анхааралтай сонсох болно. Мөн залуус, хүүхдүүд түүхийг жүжигчлэн үзүүлэхэд дуртай байдаг.

Хүүхдийн хэсгийн нэгэн багш хичээлээ үргэлж судрын түүхээр эхэлдэг байв. Жишээ нь: түүний хичээл нь эелдэг байдлын талаар байвал хичээлээ сайн Самари хүний түүхээр эхэлдэг байжээ. Хүүхдүүд дотроо дээрэмдүүлсэн эрийг бодон түүнийг хараагүй дүр үзүүлэн яаран өнгөрч байгаа хүмүүсийг төсөөлж байв. Шархдсан эрийг асарсан Самари эрийн эелдэг байдал болон хүндэтгэл хүүхдүүдэд их таалагджээ. Хүүхдүүд иймэрхүү

түүхүүдийг хүсдэг болов. Ангийн-хаа гишүүдийн анхаарлыг татахын тулд багш дуу хоолой болон үг яриагаа ашиглаж сурчээ. Тэд судартайгаа илүү танилцаж мөн сонирхон судлах болсон байна.

## **Зураг болон үзүүлэн ашигла.**

Аврагч ихэвчлэн энгийн зүйлсийг ашиглан заадаг байжээ. Хүмүүст ойлгомжтой байх үүднээс гурил, элс, чулуу болон хүмүүсийн хэрэгцээний зүйлсийг ашигладаг байжээ. Жишээ нь: Бурханы хаант улсыг үнэт эрдэнэстэй зүйрлэн Тэнгэрийн хаант улсыг өвлөж авахын тулд хүн өөрт буй бүхнээ зарах юм (Матай 13:44).



Эргэн тойрноо хар. Ангийн гишүүдийг сайн мэдээг илүү сайн ойлгоход нь туслахын тулд ямар энгийн зүйлсийг та ашиглаж болох вэ?

Сайн мэдээний зарчмуудыг дүрслэхийн тулд та энгийн үзүүлэн

болон зургуудыг ашиглаж болох юм. Сургаалын түүхийг ярихдаа сургаалын уран зургийн цуглуулгаас харуулж мөн самбар дээр эсвэл цаасан дээр зургуудыг зур.

Багш Есүсийн сургаалт зүйрлэл дээр тулгуурлан хичээл зааж байв. Ангийн гишүүд тариалангийн бүст амьдардаг тул соёолж буй улаан буудайн зэрлэгийг нь хэт эрт зулгаавал сүйдэх аюултай болохыг ойлгоно гэдгийг мэдэж байв. Тэр зэрлэгтэй холилдсон улаан буудайн жижиг багц бэлдэн хичээлд үзүүлэн болгосон байна.

Өөр нэгэн багш ангийн гишүүдийг наманчлалтай харьцуулж болох ямар нэгэн зүйлийг бодож олохыг хүсэв. Нэгэн гишүүн наманчлалыг савантай зүйрлэв. Ингэснээр энэ нь биднийг нүглээс цэвэршүүлж чадах юм.

## **Дуу хөгжим ашигла.**



Хөгжим нь ангид Их Эзэний сүнсийг урих онцгой арга юм. Хөгжим

нь үг хэлээр илэрхийлэхэд хэцүү мэдрэмжийг илэрхийлэхэд бидэнд тусалдаг.

Сүмийн дууллиуд нь сайн мэдээний маш олон зарчмуудыг заадаг бөгөөд ямар ч хичээлд ашиглахад тохиромжтой байдаг. Та хэн нэгнийг хэсэг бүлгээр нь, гэр бүл, ангиар нь хичээлтэй холбоотой дуулал дуулахыг урьж болно. Мөн хэн нэгэн хөгжимдөж байхад та дууллын үгсийг чангаар уншиж мөн дууллын бичлэгийг ашиглаж болох юм.

Багш үйлчлэлийн тухай хичээл бэлтгэжээ. Тэрээр хичээлийнхээ гол санааг нь дэмжсэн нэгэн дуулал сонгожээ. Тэрээр нэг эгчийг намуухнаар аялж, өөр нэг эгчийг үгийг нь уншуулахаар бэлтгэсэнээ хичээлийн дундуур явуулав. Дууллын үгсийг уншиж байх зуур бусад гишүүдийг үгсийн талаар эргэцүүлэн бодохыг хүсчээ. Энэ хөгжим нь тэднийг үйлчлэлийн чухлын талаар илүү хүчтэйгээр мэдрэхэд нь тусалжээ.

## **Тунгаан бодуулж, яриаг өрнүүлэх асуултуудыг асуу.**

Та хичээлдээ зөв асуултуудыг асуунаар бусдыг анхааралтайгаар суралцаж, ярилцахад тусална. Асуулт болон ярилцлага нь олон талын ашигтай. Эдгээр нь ангийн гишүүдийг хичээлийн турш анхааралтай хэвээрээ үлдэхэд тусалдаг. Гишүүдийг хичээлээ ойлгосон эсэхийг та

мэдэж чадна. Асуултуудад хариулж, түүний талаар ярилцсанаар гишүүд бие биедээ зааж чадна. Тэд өөрсдийн амьдралдаа сайн мэдээний зарчмуудыг хэрхэн хэрэгжүүлэх тухай сурч чадна.



Хичээлээ бэлдэж байхдаа ямар асуулт асуухад дараах зөвлөмжүүд танд тусална.

- Сайн мэдээний талаар болон энэ нь тэдний амьдралд хэрхэн хэрэглэгдэж болох талаар бодоход туслах асуултуудыг асуу. Бодол төрүүлэх асуултууд нь ихэвчлэн яагаад?, хэрхэн? гэсэн асуултууд байдаг. Тийм эсвэл үгүй буюу ерөнхийдөө ганц үгээр хариулагдах асуултууд тавихаас зайлсхийх хэрэгтэй.

Жишээ нь: өөрсдийн амьдралаа Аврагч дээр суурилуулах талаар хичээл зааж байвал дараах асуултуудыг та асууж болох юм:

“Христийн хадан дээр суурилах гэсэн нь юу гэсэн утгатай вэ?”

“Христийн хаднаас бусад өөр ямар сууриуд дээр хүмүүс амьдралаа суурилуулж болох вэ?”

“Христийн хадан дээр амьдралаа суурилуулснаар та хэрхэн адислагдсан бэ?”

- Гишүүдийг хувийн бодол болон туршлагуудаасаа хуваалцахад дэмжсэн асуултуудыг асуу. Жишээ нь:

“Бурхан яагаад бидэнд байнга залбирахыг зарлиг болгосон бэ?”

“Тэр таны залбиралд хэрхэн хариулсан бэ?”

- Сайн мэдээний зарчмуудыг өөрсдийн амьдралд хэрэгжүүлэхэд нь туслах асуултуудыг ангийн гишүүдээс асуу. Жишээ нь:

“Залбиралдаа хариулт авахын тулд бид хэрхэн илүү сайн бэлдэж чадах вэ?”

“Есүс Христ бол дэлхийн аврагч гэдгийг та хэрхэн мэдэж чадах вэ?”

“Иосеф Смит бол Бурханы бошиглогч гэдэг гэрчлэлээ та хэрхэн хүчирхэгжүүлж чадах вэ?”

Хэрэв хэн нэгэн нь таны хариулж мэдэхгүй асуултыг асуувал ангийн гишүүдээс тусламж хүс. Эсвэл дараагийн хичээл дээр хариултыг өгөхөө амла.

Хэрэв таныг асуулт асуусны дараа ангийн гишүүд хэсэг хугацаанд чимээгүй байвал түүнд санаа зовсоны хэрэггүй. Тэдэнд хариултыг бодоход хугацаа хэрэгтэй байдаг. Хэрэв тэд асуултыг ойлгоогүй мэт санагдвал та асуултаа арай өөр аргаар тайлбарлах хэрэгтэй. Та хэн нэгнээс асуулт асуухдаа эхлээд тэднийг нэрээр нь дуудаад дараа нь асуултаа асуух нь зүйтэй.

Төгсгөлд нь хэлэхэд, өөрийн бүхий л бэлтгэсэн хичээлийг цагтаа багтааж заахын тулд сайн ярилцлагыг хурдан дуусгахаас болгоомжил. Хамгийн чухал нь гишүүд ариун сүнсний нөлөөг мэдэрч, сайн мэдээний талаарх ойлголтоо нэмэгдүүлж, амьдралдаа сайн мэдээний зарчмуудыг хэрэгжүүлэн сайн мэдээний дагуу амьдрах үүрэг хариуцлагаа хүчирхэгжүүлэх явдал юм.

## Онцгой зочдыг урь

Зарим нэгэн тохиолдолд онцгой зочдыг хичээлдээ урих нь зүйтэй. Та сүмийн зохистой гишүүнийг түүх болон гэрчлэл хуваалцуулахаар урьж болно. Тэр хүнд хэр хугацаа байгааг хэлэх хэрэгтэй. Таны тойрог болон салбараас гадуур амьдардаг зочныг урихаасаа өмнө бишоп эсвэл салбарын ерөнхийлөгчөөсөө зөвшөөрөл ав.

Ахлагч нарын чуулганы нэгэн ерөнхийлөгч нэг гишүүнийг


хичээлдээ урьж айлчилсан айлын-  
хаа хүүхдүүдэд хэрхэн сонирхол-  
той хичээл заасан аргаасаа заахыг  
хүсчээ. Ахлагч нар гэрийн багш-  
лалтын үед яагаад хүүхдүүд орол-  
цох хэрэгтэй байдаг талаар шинэ  
ойлголт олж аваад зогсохгүй, хүүх-  
дүүдийг оролцуулахад тусалж  
болох олон аргыг сурчээ.

## **Үйл ажиллагануудыг хэрэглэ**

Хичээлтэй холбогдсон энгийн үйл  
ажиллагаанууд нь гишүүдэд тэр  
тусмаа хүүхдүүдэд сайн мэдээний  
зарчмуудыг сурахад нь тусалдаг.  
Иймэрхүү үйл ажиллагаанууд нь  
сайн мэдээг сурахад тохиромжтой  
байдаг.

## Хичээлээ бэлтгэ

---



Сайн мэдээний зарчмыг илүү үр дүнтэйгээр заахын тулд хичээлээ илүү анхааралтайгаар бэлдэхэд доорх зөвлөмжүүд танд тусална.

### **Эх сурвалжуудыг харьцуул**

Сүмээс бошиглогчдын зааврууд болон судрууд дээр тулгуурлан хүлээн зөвшөөрөгдсөн сургалтын материалыг хянамгайгаар бэлтгэсэн. Санваартан болон удирдагчдаас нь доорх материалууд боломжтой эсэхийг асуу:

- Сүмээс хичээлд тань зориулан гаргасан багшийн гарын авлага
- Ангийн гишүүдэд зориулсан судрууд

- Хожмын үеийн бошиглогчдын сургамжуудыг багтаасан сүмийн сэтгүүлүүд
- Судраас суралцах туслах материал төрөлх хэл дээр тань боломжтой байгаа эсэх
- Сайн мэдээний уран зургийн цуглуулга гэх мэт зарим судрууд таны харьяалагдах сүмийн байрны номын санд байх ёстой.

Бусад боломжтой материалуудыг хай. Тэгснээр та тэдгээрийг хичээлдээ хэрхэн хэрэглэх талаар төлөвлөж чадна. Та үр дүнтэй багш байхын тулд хичээлийн материалаа хэт нарийн боловсронгуй байлгах хэрэггүй. Христ маш олон хичээлийг даруу орчинд заадаг байсан.

Таны хичээлийн хамгийн чухал нөлөөлөл бол сүнс юм. Ариун Сүнсний удирдамжтай хамт тохирсон материалыг хэрэглэх нь сайн мэдээг сурах агуу боломжийг бүрдүүлдэг.



## Урьдаас бэлдэж эхэл

Хичээлээ урьдаас бэлдэж эхэл. Хичээл заахаасаа хэдэн долоо хоногийн өмнө бэлдэж эхэлвэл тустай. Энэ нь хичээлийн сэдвийг сайн тунгаан бодож үүний талаар залбирч мөн хангалттайгаар бэлдэхэд тань тусална.

## Хичээлийнхээ зорилгод анхаарлаа хандуул

Таны зааж буй хичээл бүр зорилготой байх ёстой. Жишээ нь: хичээлийн сэдэв мацаг барилтын талаар байвал энэ нь гишүүдийг мацаг барилтаас ирдэг адислалууд юм уу хүндэтгэлийн өдөр онцгой зорилгын төлөө мацаг барихын чухлыг ойлгоход нь туслах болно. Хичээлийн танилцуулга болон ярилцлага нь зорилго дээр төвлөрсөн байх ёстой.

Хичээлийн зорилгыг шийдвэрлэхийн тулд хичээлтэй холбогдсон материал болон судруудыг судал. Таны зааж байгаа хүмүүс хичээлээ тань чухал захиасыг нь ойлгоход нь туслахын тулд Их Эзэнээс тусламж хүс. Хичээлийн үр дүн зааж байгаа хүмүүсийн амьдралд хэрхэн нөлөөлөх талаар өөрөөсөө асуу. Сүмээс гаргасан хичээлийн гарын авлагад хичээлүүдийн зорилгыг тодорхойлсон байдаг. Эдгээр тодорхойлолтууд нь зааж байгаа хүмүүст нөлөөлөхөд туслах болно.

## Юу заахаа шийдвэрлэ.

Хичээлийнхээ зорилгыг тодорхойлсны дараа үүнийг хэрэгжүүлэхэд аль зарчим заагдах ёстойг шийдвэрлэ. Ихэнх гарын авлагууд судар, түүх болон бусад мэдээллүүдийг багтаасан байдаг. Гэхдээ хичээлүүд хугацаат цагаас илүү материалыг агуулсан байдаг. Энэ тохиолдолд та хэрэгтэй материалыг сонгох хэрэгтэй. “Тэдэнд одоо учирч байгаа бэрхшээлүүдийг давахад ямар сургаал зарчим нь илүү туслах вэ?” гэж өөрөөсөө асуу.

Танд хэрэгтэй бусад материал Тэргүүн Зөвлөлийн Захиас бичиг, Айлчлагч багшийн захиасууд болон сүмийн материал ялангуяа ерөнхий чуулганы захиасуудаас хэрэглэж болохыг анхаар.

Та юу заахаа шийдэхдээ:

- Залбиралтайгаар хичээлийн агуулгыг судал.



- Хичээлд холбогдолтой гол зарчмууд болон сургаалын жагсаалт гарга.
- Үргэлж зааж байгаа хүмүүсийнхээ хэрэгцээ болон ахуй байдлын талаар бод.
- Сүнсний удирдамжийг дага.

Нэг юм уу хоёр үндсэн зарчим дээр тулгуурлах нь ихэнхдээ оновчтой байдаг.

### **Хэрхэн заахаа шийд**

Та сэдвээ сонгосны дараа хэрхэн заахаа шийдэх ёстой. Зааж байгаа хүмүүсдээ хичээлээ хүргэхийн тулд материалуудыг сайн судалж мөн залбиралтайгаар шилдэг арга замуудыг сонго. Таны заах арга барил хүмүүст ойлгомжтой байх ёстой.

Та сургаал болон зарчмуудыг заахад тус болох судар, түүх, бусад мэдээллүүдээ сайтар судал. Гишүүдэд судруудыг хэрхэн амьдралдаа хэрэгжүүлэхэд нь туслахад бэлд (1 Нифай 19:23).

Мөн өөрийнхөө болон ангийн гишүүдийн амьдралаас жишээ болгох талаар бодож үз. Жишээ нь: нэгэн өсвөр насны хүү ахлагч нарын чуулганы ангид сууж багшийн ахынхаа тамхи татах зуршлаа хэрхэн орхисон талаарх туршлагаа хуваалцсан мөчөөс хойш тамхи татахаа больсон энэ жишээ тамхи татдаг хүн энэ зуршлаа

хаяж амьдралаа өөрчилж чадна гэдгийг тодорхойлсон юм.

Заах арга барилын талаарх мэдээлэл нь таныг хичээлээ явуулахад тусална. Энэхүү удирдамжийн 9-12 хуудсаас харна уу.

### **Хичээлээ дуусгахад бэлд**

Аврагч олон удаа зааж байгаа зүйлсээ дүгнэж тэднийг өөрсдийнх нь амьдралд хэрэгжүүлэхийг урамшуулж байсан (Сайн санаат Самари хүний зүйрлэл Лук 10:30-37). Хичээлийнхээ төгсгөлд хичээлээ эргэн харж мөн заасан зүйлээ дүгнэх хэрэгтэй. Сайн мэдээний сургаал болон зарчмуудыг хэрэгжүүлэх арга замуудыг зөвлөж мөн тэднийг бас өөр арга замуудыг зөвлөхийг урь. Тэднийг тэдгээр санаануудын аль нэгийг нь ирж буй долоо хоногт туршиж үзэхийн дэмж. Тэгснээр ирэх долоо хоногт өөрсдийн гаргасан хүчин чармайлтаасаа юу сурсан талаар асууж болох юм.

Гишүүд бүх нийтийн үйлчлэлийг долоо хоногийн өдөр бүр хийхээр уригджээ. Багш тэднээс дараагийн хичээлийн эхлэлд товчхон илтгэл тавихыг хүсчээ. Хэсэг гишүүн урамтайгаар өөрсдийн туршлага болон энэхүү хичээлийг дадлага болгосноос ирсэн баяртай мэдрэмжээ хуваалцжээ. Гишүүдийн энэхүү гайхалтай хариултууд тэднийг бие биедээ агуу үйлчлэлийг үзүүлэх хүслийг бий болгожээ.



## Зааж байгаа зүйлсээ ойлго

---



Зааж байгаа зүйлсээ ойлгох нь чухал. Ангийн гишүүдийн онцлогт тохируулан заах туршлагын талаар эргэцүүлэн бод. Өөр өөр насны хүмүүсийн хэрэгцээ болон сурах арга замууд өөр өөр байдаг.

### Хүүхдүүд

Хүүхдүүд бие махбод, нийгмийн хүрээ, сэтгэл санаагаар мөн сүнс-лэг байдлаараа өсч байгаа. Хичээлээ бэлдэж байхдаа хүүхэд бүрийн авьяас, хүчин чадал болон хэрэг-цээг санагтун.


Хүүхдүүд төрөл бүрийн зүйлд баярладаг. Тэдний сонирхолыг хадгалахын тулд богино түүх, энгийн тоглоом, бодит үзүүлэн болон дууллыг ашигла.

Хүүхдүүд эелдэг болон тэвчээртэй байдлыг хуваалцах талаар дөнгөж сурч эхэлж байна. Энэ талаар тулгарсан асуудлуудыг давахад нь туслахын тулд Есүсийн үлгэр жишээний тухай тэдэнд сануулж, Түүнийг дагахыг урамшуулан дэмж.

Хүүхдүүд аливаа юманд амархан итгэдэг. Тэд таны зааж байгаа зүйлст итгэнэ. Мөн тэд таны жишээнүүдийг ажиглаж мөн дагадаг.

### Өсвөр үе

Хүүхэд шилжилтийн насандаа заримдаа хэцүү, сорилт шалгууртай учирдаг. Ийм суралцагчид гэр бүл, сургуульдаа олон үүрэг



даалгавартай байдаг. Дараах зөвлөмжүүд өсвөр үеийнхэнд сайнаар нөлөөлөхөд тань туслах болно.

Хичээл бүрээ тэдний амьдралтай шууд холбогдохоор бэлд. Сайн мэдээ тэдний асуултанд хэрхэн хариулдгийг харахад мөн тэднийг зөв сонголтууд хийхэд нь тусал.

Өсвөр насныхан өөрсдийгөө ганцаардмал, үнэлэгдэхгүй байгаа мэт боддог. Хүн бүрийг ангийнхаа хамт олны нэгэн чухал хэсэг байхад нь тусал. Сайн мэдээний жишиг бүхий бүлэгт харьяалагдах нь өсвөр үеийнхэнд сүнслэг хүч чадлаа өсгөж амьдралаа цэвэр хадгалахад нь тусална.

Тэдний үзэл бодлыг хүндэлж байгаагаа харуул. Тэднийг хичээлд

оролцон бодол санаагаа хуваалцахыг дэмж.

## **Насанд хүрэгсэд**

Насанд хүрсэн гишүүд өөр өөр нас, өөр өөр нөхцөл байдалтай бөгөөд тэдний өссөн орчин, амьдралын туршлага нь ялгаатай юм. Эдгээр ялгаануудыг хамт олныхоо эв нэгдлийг сайжруулахад ашигла. Гишүүдийг туршлагаасаа мэдэж авсан мэдлэгээсээ хуваалцахыг хүс. Тэдэнд байдаг олон авьяасыг ашигла.

Сайн мэдээний үнэнүүдийг энгийнээр заа. Ариун Сүнс тэрхүү үнэнийг тэд амьдралдаа хэрэгжүүлэн ойлгоход нь тусална.

## Заахын ашиг тус

---



Багшийн хувьд та бусдад сайн мэдээний мэдлэгт өсч хөгжихөд нь тусалснаар ирдэг баяр баясгаланг мэдэрнэ. Таны бусдад сайн мэдээг заах хичээнгүй болон итгэлтэй хүчин чармайлт бусдад Аврагчийн талаар болон зарлиг тушаалын дагуу амьдрах гэрчлэлээ улам хүчтэй болгон хөгжүүлэхэд нь тусалдаг.

Ням гарагийн ангийн нэгэн багш ангид нь өөрөөс нь илүү их мэдлэгтэй олон хүн байгаад их санаа зовж байжээ. Түүний хичээл нь суралцагчдад эерэгээр нөлөөлж буйг мэдэрч гайхширч байлаа. Нэгэн бүтэн сайн өдөр ангийн нэг гишүүн түүнийг хажуудаа суухыг

хүсэв. Тэгээд өөрийнх нь заадаг ангид байдаг сүнслэг туршлагын улмаас нөхөр нь гэр бүлийнхнээ цуглуулж өдөр бүр хамтдаа залбирдаг болсон тухай гэр бүлээрээ мөнхийн холболт хийлгэхээр ариун сүм явах болсон талаар хуваалцжээ. Гишүүн хичээлдээ хайр болон сүнсийг урихад гаргасан хүчин чармайлтад нь талархдагаа илэрхийлэхэд багшийн зүрх сэтгэл даруусаж, хичээл заахын зорилго болон ашиг тусыг ойлгожээ.

Зааснаар та сурагчдаар адислагдах болно. Та сайн мэдээний хичээлүүдээс суралцан, бэлдэж зааснаар сайн мэдээний талаар таны мэдлэг болон Аврагчийн талаар

гэрчлэл тань хүчирхэгжинэ. Та  
бусдыг хайрлах агуу хайрыг  
мэдэрнэ. Зааж байгаа зүйлийнхээ  
дагуу даруухнаар болон хичээн-  
гүйлэн амьдарснаар сүнсний

тайвшралыг амьдралдаа мэдрэх  
болно. Багшийн үйлчлэлээр дам-  
жуулан амьдрал тань адислагдах  
болно.

# Салбар дахь удирдаж буй багшийн өсөлт хөгжилт

---



Салбарын ерөнхийлөгчийн зөвлөл салбарт заагдах хичээлд хяналт тавих үүрэгтэй.

## **Багшийг хөгжүүлэх хөтөлбөрийн зохион байгуулагчийн үүргүүд**

Салбарын гишүүнчлэл өсөх тусам салбарын ерөнхийлөгчийн зөвлөл багш нарын ахицыг хянахаар багшийг хөгжүүлэх хөтөлбөрийн зохицуулагчийг дуудаж томилдог. Зохицуулагч нь ах эгчийн аль нь ч байж болно. Салбарын зөвлөлийн гишүүд нь сайн мэдээг заах чанараа хөгжүүлэх хүчин чармайлтад нь багш нар, санваартан болон туслахуудад туслахаар үйлчилдэг.

Зохицуулагч нь удирдагчдын төлөвлөгөөнд тусалж, багшийг хөгжүүлэх сургалтыг хөтлөн явуулж, томилогдсон үед сайн мэдээний цуврал хичээлийг заана.

## **Багш нарыг дэмжих удирдагч**

Санваартан болон туслах бүлгийн удирдагч нар салбартаа сайн мэдээ чанартай заагдаж байгаа тал дээр хяналт тавих үүрэгтэй. Тэд сайн багшийг бэлдэж, дуудлагынх нь чухлыг ойлгуулдаг. Тэд багш нартаа талархал болон дэмжлэгийг үзүүлдэг. Удирдагч нар багш нарт тусламж дэмжлэгийг үзүүлж

анхаарал тавьснаар сүм дэх сургалтын чанар дээшилнэ.

## **Багшийг хөгжүүлэх сургалт**

Бүх санваартан, туслах бүлгийн удирдагч болон багш нар сайн мэдээг суралцах, заах чадвараа хөгжүүлэх, ур чадвар, арга барил болон зарчмуудыг сурахын тулд гурван сар тутамд багшийг хөгжүүлэх сургалтад сууна. Багшийг хөгжүүлэх хөтөлбөрийн зохицуулагч санваартнууд болон туслах бүлгийн удирдагч нартай зөвлөлдөж багшийг хөгжүүлэх хурлын цагийн хуваарь болон төлөвлөгөөг гаргана. Хурлыг багш нар болон удирдагч нарын тохиромжтой цагт хийх ёстой бөгөөд бүтэн сайн өдөр тогтмол явагддаг хурлуудтай давхцахгүй, нэг цагаас хэтрэхгүй байх ёстой.

Багшийг хөгжүүлэх сургалтад дараах зүйлс багтана. Үүнд:

- Салбарын зөвлөлийн гишүүд болон санваартан, туслах бүлгийн удирдагч нараас заах болон суралцах зарчмын талаар товч захиас хэлэхийг хүс.
- Багш нар, санваартан болон туслах бүлгийн удирдагч нарын заах арга барилын талаар танилцуулга.
- Багш болон удирдагч нар онцгой гишүүдэд туслалцаа үзүүлэх арга замуудын талаар ярилцах цаг.

Салбарт багш болон удирдагчдын тоо өсөх тусам багшийг хөгжүүлэх хурал нь дараах насны ангиллаар явагдана :

- 18 болон түүнээс дээш насны гишүүдийн багш болон удирдагчид.
- 12-оос 17 насны гишүүдийн багш болон удирдагчид.
- Хүүхдийн хэсгийн багш болон удирдагчид.

Эдгээр хурлыг сард нэг удаа хийнэ.

## **Сайн мэдээг заах цуврал хичээл**

Сайн мэдээг заах сургалт нь гэртээ болон сүмдээ сайн мэдээг илүү сайн заахад багш нарт туслах үндэс суурь болно. Сургалтын товч мэдээлэл нь энэ номын 21-22 дахь хуудаст байгаа. Салбарын ерөнхийлөгч өөр хэн нэгнийг заахаар томилоогүй бол хөтөлбөрийн зохицуулагч нь сургалтыг заана.

Салбарын ерөнхийлөгчийн зөвлөл гишүүдийг хичээлд хамрагдахыг уриалж, гишүүдийг оролцуулахын тулд нэг анги арваас дээшгүй хүнтэй байна.

# Сайн мэдээг заах цуврал хичээлийн тэмдэглэл

---

Цуврал хичээл нь сүмийн бүх гишүүнийг илүү сайн багш байх боломжоор хангадаг. Багш нь багшийг хөгжүүлэх хөтөлбөрийн зохицуулагч эсвэл салбарын ерөнхийлөгчөөр дуудагдсан туршлагатай гишүүн байна. Уг сургалт нь ням гарагийн ангийн хичээлийн үеэр эсвэл өөр тохиромжтой цагт заахаар төлөвлөх ёстой. Хэрэв сургалтыг тодорхой зохион байгуулалттайгаар багш болон удирдагч нарт зориулан хийх гэж байгаа бол тогтмол явуулах сургалт болгож болно. Ням гарагийн хичээлийн үеэр явуулахад байр болон бусад зүйлийн гачигдалтай байгаа бол гэрийн сургалт хэлбэрээр явуулж болно (цөөхөн тооны хичээл).

Хичээл бүрд зориулсан санаанууд энэ номонд байгаа. Багш хичээлээ бэлдэхдээ “Төрөл бүрийн заах арга барилыг ашигла” хэсэгт буй зөвлөгөөнүүдээс ашиглаж, хичээлийн төгсгөлд тухайн өдөр сурсан зүйлсээ гэр бүлийн үдэш эсвэл сүмийн хичээлүүдэд хэрэгжүүлэхийг дэмж. Энэ нь багшийн өсөлт хөгжлийг маш ихээр нэмэгдүүлнэ. Сургалт нь дараах хуваарийн дагуу найман долоо хоногийн турш үргэлжлэх ёстой. Дараах зөвлөмжүүд нь хичээл заах багш нарт хамааралтай.

## Нэг дэх долоо хоног

Гишүүн бүрд энэ гарын авлагыг тараан агуулгатай нь танилц. “Өөрийгөө сүнслэгээр бэлд” хэсэгт болон оршил хэсэгт хичээлээ төвлөрүүл. Онцгойлон адис хүртсэн байх болон Ариун Сүнстэй байх шаардлагыг хангахын тулд сайн мэдээгээр амьдрахын чухлыг онцол.

## Хоёр дахь долоо хоног

“Есүсийн адил заа” хэсэгт байгаа “Зааж байгаа хүмүүсээ хайрла” хэсгийг ярилц. Энэ нь мөн удирдамжийн 16-17 хуудас дахь насны бүлгийн онцлогуудыг дурдсан байдаг. Ангийн болон гэр бүлийн гишүүддээ хайраар нөлөөлсөн нь хэрхэн эерэг үр нөлөөг авчирсан туршлагаасаа хуваалцахыг гишүүдээс хүс. Мөн багш нар хөгжлийн бэрхшээлтэй гишүүд болон шинэхэн хөрвөгчдөд хэрхэн хүрч тэдний хэрэгцээнд тулгуурлан туслах талаар ярьж болох юм.

## Гурав дахь долоо хоног

“Есүсийн адил заа” хэсэг дэх “Сайн Мэдээний үнэнүүдийг заа” сэдэвт анхаарлаа төвлөрүүл. Сайн мэдээний хувийн сургалтын төвлөгөөг бий болгох, судруудыг хэрэглэх болон сургаалыг итгэлтэй, тодорхой болон энгийнээр заахын чухлыг онцол.



## **Дөрөв дэх долоо хоног**

“Есүсийн адил заа” хэсэг дэх  
“Сүнсээр заа” сэдвийн заах чадварыг бий болгож чадна гэдэг дэмжлэгийг мэдрэхэд нь ангийн гишүүдэд тусал. Тэдэнд сүнсийг ялган таньж мөн түүнийг дагахад нь тусал.

## **Тав дахь долоо хоног**

“Есүсийн адил заа” хэсэг дэх  
“Хичээнгүй суралцахыг бий болго” сэдвийг ярилц. Зааж байгаа хүмүүс сайн мэдээг суралцаж, үүний дагуу тууштайгаар амьдрах үүргээ хүлээн авахад нь багш нар тусалж болох онцгой арга замуудыг онцол.

## **Зургаа дахь долоо хоног**

“Есүсийн адил заа” хэсэг дэх  
“Сурах орчныг бүрдүүл” хэсгийг ярилц. Сурахыг хүсч байгаа оролцогчдын дунд сурах орчныг бий болгох нь хэр чухал болохыг ойлгоход нь гишүүдэд тусал.

## **Долоо дахь долоо хоног**

“Төрөл бүрийн заах арга барилыг ашигла” хэсгийг ярилц. Үр дүнтэй хичээлийг хөгжүүлэхэд эргэцүүлэл, бүтээлч байдал зэрэг энэ хэсэгт байгаа материал нь маш их тустай. Энэ хэсэгт агуулагдсан заах арга барилын талаар ямар нэг туршлага байгаа бол гишүүдийг туршлагаасаа хуваалцахыг хүс.

## **Найм дахь долоо хоног**

“Хичээлээ бэлд” хэсгийг ярилц. Хичээлийг хэрхэн үр дүнтэй заах, төлөвлөх болон хичээлээ эрт бэлдэж эхлэхийн чухлыг ойлгоход нь гишүүдэд тусал.

Сургалт явагдаж байхад тохиромжтой үе гарвал “Заахын ашиг тус” хэсэг дэх үндсэн сууриудыг онцолж болно. Ангийн гишүүдээс багш нар амьдралыг нь хэрхэн адисалсан арга замуудаас нь болон багшийн хувьд бусдын амьдралд хэрхэн тусалсан талаар хуваалцахыг хүс.

Сургалт явагдаж дууссаны дараа оролцогчдоод үргэлжлүүлэн хөгжиж дэвшихийг уриал. Хэрэв шинээр дуудагдсан багш бол санваартан болон туслах бүлгийн удирдагч нар тэдэнтэй уулзаж анги болон гишүүдийг танилцуулах ёстой. Багш нар удирдагч нартайгаа тогтмол уулзаж онцгой хэрэгцээ болон тулгамдсан асуудлуудын талаар ярилцан, багш нар удирдагчийг ангидаа урьж болно. Багшийг хөгжүүлэх хөтөлбөрийн зохицуулагч нь багшийн дуудлагатай болон гэр бүлүүддээ заадаг мөн удирдах үүргийг авсан бүх багшид туслах байнгын эх сурвалж юм.



# Сүмийн материалуудыг цуглуулан, мэдээллүүдийг гэр бүлийн түүх дээр байрлуулах

---

Сүмийн хангамжийн төв, үйлчлэлийн төв, Солт Лэйк хотын хангамжийн төв болон сүмийн албан ёсны интернэт хаяг [www.lds.org](http://www.lds.org)-аас ариун сүмийн хувцас, гармэнт, сүмийн сэтгүүлүүд, суралцах цуврал хичээлүүд болон судруудыг багтаасан сүмийн материалуудыг

орон нутгийн удирдагчид олж авч болно.

Гэр бүлийн түүхийн ажлын талаарх мэдээлэл нь [www.familysearch.org](http://www.familysearch.org) гэсэн гэр бүлийн түүхийн хаягт байгаа.